# НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/59 Улаанбаатар хот

Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн хэмжээнд зохион байгуулах Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж, холбогдох зардлыг тухай бүр санхүүжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1123000173

AJIL\2023 он ажил\захирамж

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 22 -ны өдрийн А/159
дугаар Захирамжийн хавсралт

# НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөж, батлуулах, хэрэгжилтийг хангах | -Төлөвлөгөөг батлуулсан байх<br>-Тайлагнасан байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |
| | | 1.2. АТГ-аас бэлтгэсэн тв, шторк, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож тайлагнасан байх /түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо/<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |
| | | 1.3. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах | -2-оос дээш өдөрлөг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх<br>-Үр дүнг тооцож нотломжийг хавсаргасан байх | Засаг даргын Тамгын газар,<br>Төрийн болон төрийн бус байгууллагууд |
| | | 1.4 Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбар байршуулах | -Мэдээллийн самбар байршуулсан байх<br>-Мэдээллийг сар бүр шинэчилсэн байх | Засаг даргын Тамгын газар |
| 2 | Авлигын эсрэг | 2.1 АТГ-аас зохион байгуулдаг | -Шинээр томилогдсон албан | Засаг даргын Тамгын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-ын сургалтад хамруулах | авлигын эсрэг анхан шатны болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулах | хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх<br>-Сургалт, мэдээлэл авсан байх | газар |
| | | 2.2 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн дотоод нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнах | -Сургалт зохион байгуулсан байх<br>-Үр дүн нь олон нийтэд хүрсэн байх<br>-Иргэдийн мэдлэг, чадвар дээшилсэн байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |
| 3 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх хариуг хугацаанд нь мэдэгдэх | 3.1 “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүн тооцож, тайлагнах | -Шүгэл ажиллагаа<br>-Шүүр ажиллагаа<br>-Шувуу ажиллагаа<br>-Шилжүүлэн авах ажиллагаа<br>-Шил ажиллагааг үйл ажиллагаандаа тусган ажилласан байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |
| | | 3.2 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, саналыг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах | -Үйл ажиллагаандаа тусган ажилласан байх<br>-Үр дүн нь олон нийтэд хүрсэн байх | Засаг даргын Тамгын газар |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд хамрагдах | -Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулагдсан байх<br>-Иргэдийн авлигын талаарх мэдлэг дээшилсэн байх | Засаг даргын Тамгын газар,<br>Төрийн бус байгууллагууд |
| | | 4.2 Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа | -Хэрэгжүүлж буй арга хэмжээ авлигаас урьдчилан | Засаг даргын Тамгын газар, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгуулах | сэргийлсэн байх | Төрийн бус байгууллагууд |
| | | 4.3 Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах | -Сэтгэл ханамжийн судалгаа авсан байх<br>-Судалгааны үр дүнг тооцсон байх | Засаг даргын Тамгын газар |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 5.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах | 6.1 Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дахь заалт,<br>6.2 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дахь хэсэг,<br>6.3 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийт үзэж танилцах боломжоор хангах | -Төсвийн орлого, түүний зарцуулалтыг олон нийтэд тухай бүр мэдээлсэн байх<br>-Төсөвт орсон өөрчлөлт, орон нутгийн хөгжлийн сан, худалдан авах ажиллагааны мэдээллийг олон нийтэд тухай бүр мэдээлсэн байх<br>-Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааг мэдээллийн самбарт нийтэд ойлгомжтой байрлуулсан байх | Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагууд |